



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

“Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц,  
орон тооны хязгаар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Засгийн газрын бүтцийн тухай хууль, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дараах яамдын зохион байгуулалтын бүтцийг доор дурдсанаар баталсугай:

1/Эдийн засаг, хөгжлийн яам:

1. Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар (Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтэс, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтэстэй);
2. Макро эдийн засгийн бодлогын газар (Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтэс, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтэс, Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтэстэй);
3. Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газар (Шинжлэх ухааны бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтэстэй);
4. Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газар (Худалдааны бодлогын хэлтэс, Хамтын ажиллагааны хэлтэс, Эдийн засгийн коридорын хэлтэстэй);
5. Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газар (Төслийн санхүүжилт, мониторингийн хэлтэс, Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтэс, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтэстэй);
6. Аж үйлдвэр, салбаруудын шинэчлэлийн нэгдсэн бодлогын газар (Аж үйлдвэрийн төлөвлөлт, орон зайн судалгааны хэлтэс, Салбарын шинэчлэл, бизнесийн орчныг дэмжих хэлтэстэй);
7. Төрийн захиргааны удирдлагын газар (Хуулийн хэлтэс, Хүний нөөцийн хөгжлийн хэлтэс, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэстэй);
8. Хяналт, шинжилгээ, үнэлгээний газар.

## 2/Гадаад харилцааны яам:

- 1.Бодлогын газар (Судалгаа, дүн шинжилгээний хэлтэс, Гадаад сурталчилгаа, мэдээллийн хэлтэстэй);
- 2.Хөрш орнуудын газар;
- 3.Америк, Ойрхи Дорнод, Далайн орнуудын газар;
- 4.Азийн газар;
- 5.Европ, Африкийн газар;
- 6.Олон талт хамтын ажиллагааны газар;
- 7.Олон улсын худалдаа, эдийн засгийн газар;
- 8.Консулын газар;
- 9.Гэрээ, эрх зүйн газар (Хилийн хэлтэстэй);
- 10.Ёслолын газар;
- 11.Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтын газар (Хүний нөөц, сургалтын хэлтэс, Санхүү, бүртгэлийн хэлтэс, Гадаад харилцааны төв архивтай);
- 12.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.

## 3/Хууль зүй, дотоод хэргийн яам:

- 1.Хууль зүйн бодлогын газар (Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтэс, Нийтийн эрх зүйн хэлтэс, Хувийн эрх зүйн хэлтэстэй);
- 2.Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газар (Олон улсын арбитрын хэлтэстэй);
- 3.Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтэстэй);
- 4.Сургалт, сурталчилгаа, хөтөлбөрийн хэрэгжилтийн газар;
- 5.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;
- 6.Төрийн захиргааны удирдлагын газар (Мэдээллийн технологийн хэлтэстэй);
- 7.Санхүү, хөрөнгө оруулалтын газар.

## 4/Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам:

- 1.Аж үйлдвэрийн бодлогын газар (Бодлого төлөвлөлт, судалгааны хэлтэс, Инновац, түншлэл, хамтын ажиллагааны хэлтэстэй);

- 2.Эрдэс баялгийн бодлогын газар (Геологи, цөмийн энергийн хэлтэс, Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтэстэй);
- 3.Үйлдвэр, технологийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
- 4.Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
- 5.Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
- 6.Төрийн захиргааны удирдлагын газар (Хуулийн хэлтэс, Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтэстэй);
- 7.Санхүү, хөрөнгө оруулалтын газар;
- 8.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;
- 9.Салбарын хяналтын газар (Цөмийн болон цацрагийн хяналтын хэлтэстэй).

5/Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам:

- 1.Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар (Уур амьсгалын өөрчлөлтийн хэлтэс, Ногоон технологи, инновацын хэлтэстэй);
- 2.Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газар (Мэдээллийн сан, кадастрын хэлтэс, Байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлтэстэй);
- 3.Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газар (Орчны бохирдлын хэлтэс, Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтэстэй);
- 4.Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газар;
- 5.Төрийн захиргааны удирдлагын газар (Хуулийн хэлтэс, Бүтээмж, мэдээллийн технологийн хэлтэстэй);
- 6.Гадаад хамтын ажиллагааны газар;
- 7.Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Санхүүгийн хэлтэстэй);
- 8.Хяналт, үнэлгээ, аудитын газар;
- 9.Салбарын хяналтын газар (Эрсдэлийн удирдлагын хэлтэстэй).

6/Боловсролын яам:

- 1.Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар (Боловсролын статистик, мэдээллийн хэлтэс, Насан туршийн суралцахуйн хэлтэс, Хоол үйлдвэрлэлийн хэлтэстэй);
- 2.Дээд боловсролын газар;
- 3.Мэргэжлийн болон техникийн боловсролын газар;

- 4.Боловсролын газар (Сургуулийн өмнөх боловсролын хэлтэс, Тэгш хамран сургах боловсролын хэлтэстэй);
- 5.Цахим боловсролын газар;
- 6.Гадаад хамтын ажиллагааны газар;
- 7.Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Санхүүгийн хэлтэс, Хөрөнгө оруулалтын хэлтэстэй);
- 8.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;
- 9.Салбарын хяналтын газар;
- 10.Төрийн захиргааны удирдлагын газар (Хууль, эрх зүйн хэлтэстэй).

7/Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам:

- 1.Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар (Гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй);
- 2.Төрийн захиргааны удирдлагын газар (Хууль, эрх зүйн хэлтэстэй);
- 3.Гэр бүлийн бодлогын газар (Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтэс, Гэр бүл, хүн амын хөгжлийн хэлтэстэй);
- 4.Хөдөлмөрийн бодлогын газар (Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс, Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлсний хэлтэс, Нийгмийн халамжийн хэлтэстэй);
- 5.Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газар (Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтэстэй);
- 6.Салбарын хяналтын газар;
- 7.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;
- 8.Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газар (Төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хэлтэстэй);
- 9.Цахимжилт, их өгөгдлийн бодлогын газар.

8/Зам, тээврийн яам:

- 1.Бодлого төлөвлөлтийн газар (Судалгаа, стандарт, статистикийн хэлтэс, Мэдээлэл технологийн хэлтэстэй);
- 2.Төрийн захиргааны удирдлагын газар (Хуулийн хэлтэс, Гадаад хамтын ажиллагааны хэлтэс, Санхүүгийн хэлтэстэй);
- 3.Авто замын бодлого зохицуулалтын газар (Замын ашиглалт, засварын хэлтэстэй);

4.Автотээврийн бодлого зохицуулалтын газар (Тээвэр зохион байгуулалтын хэлтэс, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын албатай);

5.Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газар (Төмөр замын тээврийн хэлтэс, Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтэстэй);

6.Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газар;

7.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;

8.Салбарын хяналтын газар.

9/Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам:

1.Стратеги, бодлого төлөвлөлтийн газар (Цахим бодлого, статистик мэдээллийн хэлтэс, Нэгдсэн төлөвлөлтийн хэлтэстэй);

2.Төрийн захиргааны удирдлагын газар (Хүний нөөцийн хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэстэй);

3.Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

4.Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

5.Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

6.Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

7.Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

8.Гадаад харилцаа, олон улсын мэдээлэл сурталчилгаа, хамтын ажиллагааны газар (Мэдээлэл, сурталчилгааны хэлтэстэй);

9.Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Хөрөнгө оруулалтын хэлтэстэй);

10.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;

11.Салбарын хяналтын газар.

10/Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам:

1.Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газар (Орон сууцжуулалтын хэлтэс, Статистик, мэдээллийн сангийн хэлтэстэй);

2.Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газар (Хот дахин төлөвлөлтийн хэлтэстэй);

3.Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газар (Барилгын материалын хэлтэстэй);

- 4.Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газар (Инженерийн дэд бүтцийн хэлтэстэй);
- 5.Төрийн захиргааны удирдлагын газар (Хуулийн хэлтэс, Гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй);
- 6.Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Санхүү, төрийн сангийн хэлтэс, Төсөл, хөтөлбөрийн хэлтэстэй);
- 7.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;
- 8.Салбарын хяналтын газар (Инженерийн байгууламжийн хяналтын хэлтэстэй).

11/Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам:

- 1.Бодлого, төлөвлөлтийн газар (Хуулийн хэлтэс, Гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй);
- 2.Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Малын генетик нөөцийн хэлтэстэй);
- 3.Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Хөрс, ургамал хамгаалал, үр, сортын хэлтэстэй);
- 4.Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
- 5.Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
- 6.Төрийн захиргааны удирдлагын газар;
- 7.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;
- 8.Санхүү, хөрөнгө оруулалтын газар;
- 9.Цахимжилт, статистик, мэдээллийн газар;
- 10.Салбарын хяналтын газар.

12/Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам:

- 1.Стратеги, бодлого, төлөвлөлтийн газар (Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс, Салбарын эрх зүйн орчны шинэчлэл, хуулийн хэлтэс, Салбарын хүний нөөц, судалгааны хэлтэстэй);
- 2.Төрийн захиргааны удирдлагын газар (Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтэстэй);
- 3.Инновацын бодлого зохицуулалтын газар (Их өгөгдөл, хиймэл оюун ухааны хэлтэс, Гарааны бизнесийн экосистемийг дэмжих хэлтэстэй);
- 4.Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газар (Төрийн үйлчилгээний дахин загварчлалын хэлтэстэй);

- 5.Харилцаа холбооны бодлого зохицуулалтын газар (Сүлжээний дэд бүтцийн хэлтэс, Сансрын технологийн хэрэгжилтийн хэлтэстэй);
- 6.Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газар;
- 7.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;
- 8.Салбарын хяналтын газар.

### 13/Эрүүл мэндийн яам:

- 1.Стратеги төлөвлөлтийн газар (Салбарын хүний нөөцийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн мэдээлэл, цахим хөгжлийн хэлтэс, Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлогын хэлтэстэй);
- 2.Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газар (Халдварт өвчний хэлтэс, Халдварт бус өвчний хэлтэс);
- 3.Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Анхан болон лавлагаа шатлалын тусламжийн хэлтэс, Анагаах ухааны инновац, технологийн хэлтэстэй);
- 4.Төрийн захиргааны удирдлагын газар (Гадаад хамтын ажиллагааны хэлтэс, Хуулийн хэлтэстэй);
- 5.Санхүү, эдийн засгийн бодлогын газар (Санхүү, даатгалын хэлтэс, Хөрөнгө оруулалтын хэлтэстэй);
- 6.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;
- 7.Салбарын хяналтын газар.

### 2.Яамдын орон тооны хязгаарыг хавсралт ёсоор тогтоосугай.

3.Яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн төслийг боловсруулан 2024 оны 08 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

4.Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд болон ажилтнууд нь чиг үүргийн давхардалгүй байхаар яамны үйл ажиллагааг зохион байгуулах, яамны бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагчдыг томилох, чөлөөлөхөд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журмыг баримталж ажиллахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

5.Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдаж, зарим яамдын нэр, эрхлэх асуудалд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгасугай:

5.1.шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн чиг үүрэгт хамаарах баримт материал, албан хаагчдыг орон тоо, цалингийн сангийн хамт Эдийн засаг, хөгжлийн яаманд, цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, хяналт тавих чиг үүрэгт хамаарах баримт материал, албан

хаагчдыг орон тооны хамт Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд тус тус шилжүүлэхийг Боловсролын сайд П.Наранбаярт;

5.2.бүсчилсэн хөгжлийн бодлого, чөлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн чиг үүрэгт хамаарах баримт материал, албан хаагчдыг орон тоо цалингийн сангийн хамт Монгол Улсын Шадар сайд (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн)-ын Ажлын албанд шилжүүлэхийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт;

5.3.аялал жуулчлалын бодлогын чиг үүрэгт хамаарах баримт материал, албан хаагчдыг орон тоо, цалингийн сангийн хамт Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд шилжүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяад;

5.4.биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого, мэргэжлийн спортын хөгжлийн асуудал, үндэсний уламжлалт спортыг дэмжих, хөгжүүлэх бодлогын чиг үүрэгт хамаарах баримт материал, албан хаагчдыг орон тоо, цалингийн сангийн хамт Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учралд;

5.5.залуучуудын хөгжил, оролцоог дэмжих бодлогын чиг үүрэгт хамаарах баримт материал, албан хаагчдыг орон тоо, цалингийн сангийн хамт Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд шилжүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгаланд.

6.Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудалд өөрчлөлт орсонтой холбогдуулан "Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын 4.1 дэх дэд заалтын "Байгаль орчин, аялал жуулчлалын газар" гэснийг "Байгаль орчны газар" гэж, 4.3 дахь дэд заалтын "Боловсрол, шинжлэх ухааны газар" гэснийг "Боловсролын газар" гэж, 4.13 дахь дэд заалтын "Соёл, урлагийн газар" гэснийг "Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар" гэж тус тус өөрчилж, мөн тогтоолын 2.8 дахь дэд заалтыг хассугай.

7.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар тогтоол, "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" Засгийн газрын 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 50 дугаар тогтоол, "Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 95 дугаар тогтоол, "Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 105 дугаар тогтоол, "Соёлын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" Засгийн газрын 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 300 дугаар тогтоол, "Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай" Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоол, "Олимп, нийтийн



Засгийн газрын 2024 оны 07 дугаар  
сарын 24-ний өдрийн 06 дугаар  
тогтоолын хавсралт

ЯАМДЫН ОРОН ТООНЫ ХЯЗГААР

№	Яамны нэр	Орон тооны хязгаар
1.	Эдийн засаг, хөгжлийн яам	135
2.	Гадаад харилцааны яам	147
3.	Хууль зүй, дотоод хэргийн яам	108
4.	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	99
5.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	122
6.	Боловсролын яам	104
7.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	137
8.	Зам, тээврийн яам	151
9.	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	130
10.	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	99
11.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	121
12.	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	98
13.	Эрүүл мэндийн яам	114

биеийн тамир, спортын Үндэсний хорооны бүрэлдэхүүн, Үндэсний хорооны дүрэм, Сайдын Ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай” Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 343 дугаар тогтоол, “Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 17 дугаар тогтоол, “Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 80 дугаар тогтоол, “Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 161 дүгээр тогтоол, “Боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тоо батлах тухай” Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 165 дугаар тогтоол, “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 441 дүгээр тогтоол, “Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 478 дугаар тогтоол, “Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 488 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Н.УЧРАЛ